



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Эзэмшил газар данс бүртгэлээс хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймаг дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 30,000,000.00 (гучин сая) төгрөгийн балансын үнэлгээ бүхий тус аймгийн Хонгор сумын 1 дүгээр баг, Зулзагын гол амралтын бүсэд байрлах, нэгж талбарын 4502003231 дугаартай, 1.5 га талбай бүхий газар эзэмших эрхийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Э.Батбаяр, Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүхийн тамгын газрын дарга Б.Бат-Амгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. "Газар эзэмших эрх"-биет бус хөрөнгийг данс бүртгэлээс хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001255